



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/13/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amariargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт	3
Хүснэгтийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.4.1 Мөнгөн хөрөнгө	14
3.4.2 Авлага	14
3.4.3 Бараа материал	15
3.4.4 Үндсэн хөрөнгө	15
3.4.5 Өр төлбөр	16
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.5.3 Нэмэлт төсөв	18
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Залруулсан алдаа	22
5.2 Төлбөрийн акт	23
5.3 Албан шаардлага	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт	13
Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	14
Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл	14
Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл	15
Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл	15
Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл	16
Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо	16
Хүснэгт 8 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт	18
Хүснэгт 9 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	21

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/248
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Б.БАТБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Архуст сум нь тайлант хугацаанд төмсний тариалалтыг 122 иргэн 11 аж ахуйн нэгж байгууллага 280.5 га талбайд хийж 4,305.7 тн ургац хураан авснаар төмсний нэгжийн ургацаар аймагтаа тэргүүлж, хүнсний ногоог 119 иргэн, 16 аж ахуйн нэгж байгууллага 241.8 га талбайд тариалж 2403.2 тн ургац хураан авснаар хүнсний ногооны нэгжийн ургацаар аймагтаа 3 дугаар байр эзэлсэн амжилт гаргасан байна.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 47 зорилт 187 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 76,8 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дугаартай албан бичгээр ирүүлсэн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийн дагуу гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын 6,473,867.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 401,332.1 мянган төгрөгийн бараа материал, 160,532.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг шилжүүлэн тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		834,753.60	482,884.74
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а 3б	267,784.48	163,162.66
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	321,379.25	218,444.13
34	УРЬДЧИЛГАА	8а, 8б, 8в	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	245,589.87	101,277.96
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,854,550.64	1,588,242.48
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	12а, 12б, 12в	-	-
39200	Биет хөрөнгө		3,585,465.61	1,353,484.95
39300	Биет бус хөрөнгө		269,085.03	234,757.53
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,689,304.24	2,071,127.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		8,767.81	4,035.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	8,767.81	4,035.00
41300	Өглөг	17а, 17б	8,767.81	4,035.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,680,536.43	2,067,092.23
51	Засгийн газрын хувь оролцоо		4,680,536.43	2,067,092.23
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,449,607.57	825,219.30
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		1,449,607.57	825,219.30
51200	Хуримтлагдсан үр дүн		2,197,054.79	1,111,370.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,033,874.07	130,502.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,689,304.24	2,071,127.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,979,072.52	1,003,772.68
11	ТАТВАРЫН ОРЛОГО	68,837.11	180,236.93
110	Орлогын албан татвар	38,222.66	130,122.66
1100	Хувь хүний орлогын албан татвар	38,222.66	133,881.53
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(3,758.87)
113	Хөрөнгийн албан татвар	15,954.70	27,999.93
118	Бусад татвар, төлбөр, хураамж	14,659.75	22,114.34
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,397.50	3,082.08
1181	Газрын төлбөр	7,888.25	18,924.26
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	374.00	108.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,587,100.87	409,632.84
120	Нийтлэг татварын бус орлого	1,587,100.87	409,632.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,323,134.54	413,902.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,055,906.20	105,921.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	157,225.26	20,695.81
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,033,791.78	287,285.50
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	76,211.30	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,570,897.36	697,556.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,570,897.36	697,556.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,879,945.56	692,567.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,101,939.57	246,220.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,954.55	31,421.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,652.31	108,682.94
2104	Хангамж, бараа материалын зардал	158,394.99	37,749.64
2105	Нормативт зардал	94,421.47	55,872.11
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,319.53	5,950.00
2107	Томилолт, зочны зардал	4,648.20	5,278.20
2108	Бусдаар түицэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,944.29	56,267.08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	259,670.66	145,125.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	690,951.79	4,989.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,695.44	4,989.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	558,741.19	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,515.17	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,408,175.16	306,216.30
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	43,419.17	3,403,069.52
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,364,756.00	(3,096,853.21)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,741,047.42	805,808.25
11	ТАТВАРЫН ОРЛОГО	68,837.11	180,236.93
110	Орлогын албан татвар	38,222.66	130,122.66
1100	Хувь хүний орлогын албан татвар	38,222.66	133,881.53
113	Хөрөнгийн албан татвар	15,954.70	27,999.93
118	Бусад татвар, төлбөр, хураамж	14,659.75	22,114.34
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,397.50	3,082.08
1181	Газрын төлбөр	7,888.25	18,924.26
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	374.00	108.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	411,990.87	211,668.40
120	Нийтлэг татварын бус орлого	411,990.87	211,668.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,260,219.44	413,902.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,055,906.20	105,921.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	157,225.26	20,695.81
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,033,791.78	287,285.50
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,296.20	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,311,509.35	575,074.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,311,509.35	575,074.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,619,491.20	568,185.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,101,156.69	246,388.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,927.15	31,421.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,528.88	110,841.29
2104	Хангамж, бараа материалын зардал	88,880.02	16,455.33
2105	Нормативт зардал	65,084.10	63,352.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,886.80	7,150.00
2107	Томилолт, зочны зардал	4,648.20	4,878.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,146.27	63,565.28
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,233.09	24,132.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	692,018.15	6,888.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,761.80	6,679.70
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	558,741.19	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,515.17	208.88
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,562.80	293,204.90
2200	Дотоод эх үүсвэрээр	37,562.80	293,204.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	429,538.07	230,734.13
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	37,562.80	293,204.90
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	242,403.29	(104,621.82)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,381.18	267,784.48
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	267,784.48	163,162.66

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,449,607.57	3,315,780.44
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,449,607.57	3,315,780.44
9	Тайлант үеийн үр дүн	-	1,364,756.00
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,449,607.57	4,680,536.43
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,449,607.57	4,680,536.43
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөл	(624,388.28)	(2,156,179.17)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	825,219.30	2,524,357.26
19	Тайлант үеийн үр дүн	-	(3,096,853.21)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	825,219.30	2,067,092.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,042,220.90	823,977.63	(4,854.30)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	523,713.10	488,621.68	(4,854.30)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	521,213.10	486,126.28	(1,103.50)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,527.40	245,618.90	-
210101	Үндсэн цалин	210,661.70	193,420.56	-
210102	Нэмэгдэл	56,118.80	43,892.16	-
210104	Урамшуулал	6,746.90	8,306.18	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,402.10	31,421.54	-
210201	Тэтгэврийн даатгал	25,460.80	21,873.41	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,735.40	2,312.31	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,188.20	1,952.38	-
210204	Ажилгүйдлийн даатгал	547.00	478.61	-
210205	Эрүүл мэндийн даатгал	5,470.70	4,804.83	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	112,983.10	110,841.29	-
210301	Гэрэл, цахилгаан	31,089.40	44,025.11	-
210302	Түлш, халаалт	80,177.90	65,275.22	-
210303	Цэвэр, бохир ус	1,715.80	1,540.97	-
2104	Хангамж, бараа материалын зардал	15,654.90	15,644.33	(103.50)
210401	Бичиг хэрэг	1,597.90	1,597.50	(103.50)
210402	Тээвэр, шатахуун	9,177.30	9,175.75	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,679.70	1,676.10	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200.00	3,194.98	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,150.00	7,150.00	(1,000.00)
210604	Урсгал засвар	7,150.00	7,150.00	(1,000.00)
2107	Томилолт, зочны зардал	4,878.20	4,878.20	-
210702	Дотоод албан томилолт	4,878.20	4,878.20	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,117.40	63,079.06	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,472.40	61,470.60	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432.00	432.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	586.00	565.46	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.00	227.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400.00	384.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,500.00	7,492.95	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000.00	4,993.40	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500.00	2,499.55	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500.00	2,495.40	(3,750.80)
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500.00	2,495.40	(3,750.80)
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500.00	2,495.40	(200.00)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	318,507.80	293,204.90	-
222001	Тоног төхөөрөмж	148,707.80	142,348.30	-
223001	Бусад хөрөнгө	169,800.00	150,856.60	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.00	42,151.05	-
230001	Эргэж төлөгдөх зээл	200,000.00	42,151.05	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,042,220.90	844,511.44	(17,463.40)
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,921.60	105,921.60	(399,950.95)
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	105,921.60	105,921.60	140,544.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	547,713.10	658,573.03	518,999.55
320001	Орон нутгийн төсвөөс	547,713.10	658,573.03	624,921.15
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	388,586.20	80,016.81	(136,512.00)
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	80,016.81	-
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	188,586.20	-	(136,512.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	88,634.69	88,765.46
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	109,168.50	109,168.50

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,773.92	20,773.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,773.92	20,773.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,076.87	14,076.87
2104	Хангамж, бараа материалын зардал	486.00	486.00
210402	Тээвэр, шатахуун	486.00	486.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.00	300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300.00	300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,290.87	13,290.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,290.87	13,290.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,697.06	6,697.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,184.30	4,184.30
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,184.30	4,184.30
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,512.76	2,512.76
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,434.65	2,434.65
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	78.11	78.11
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,695.81	20,695.81
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,695.81	20,695.81
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,695.81	20,695.81
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	78.11	78.11

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Архуст сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

“АТАР IV” аяны хүрээнд Архуст сум тариалангийн бүс нутаг тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж, тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бодлогыг дэмжин ажиллаж 2022 онд 8,743.1 га-д тариалалт хийж 21,310.53 тн ургац хураан авсан байна.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнг 79,7 хувьтай, “Ногоон хөгжил-баялаг бүтээгчид”-ийг дэмжих урианы жилийн хөтөлбөр, арга хэмжээг 77,7 хувьтай тус тус хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Архуст сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын Засаг даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу ЕБС, сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа, Худалдаа үйлчилгээний байгууллагуудын албан татвар, төлбөр хураамж төлж байгаа эсэхэд, төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэрэгт хяналт хийж, ажлын дүгнэлт тайланг бичсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,071,127.23 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,618,177.01 мянган төгрөгөөр буюу 55,8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	267,784.48	163,162.66	(104,621.82)
Авлага	321,379.25	218,444.13	(102,935.12)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	245,589.87	101,277.96	(144,311.92)
Нөөцийн бараа	-	-	-
Үндсэн хөрөнгө	3,854,550.64	1,588,242.48	(2,266,308.16)
Нийт хөрөнгийн дүн	4,689,304.24	2,071,127.23	(2,618,177.01)
Нийт өр төлбөр	8,767.81	4,035.00	(4,732.81)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,680,536.43	2,067,092.23	(2,613,444.20)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,689,304.24	2,071,127.23	(2,618,177.01)

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 163,162.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 104,621.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын данс 39,976.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 124,747.7 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сан 19,772.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 37,074.2 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 218,444.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 102,935.1 мянган төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага 102,935.1 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 101,277.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 144,311.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд харьяа байгууллагууддаа санхүүгийн тайлангаа нэгтгэдэг болсноор Эрүүл мэндийн төвийн 60,447.8 мянган төгрөг, ЕБС-ийн 44,251.3 мянган төгрөг, СӨБ-ийн 30,627.8 мянган төгрөг, Соёлын төвийн 34,513.6 мянган төгрөгийн, нийт 169,840.5 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,588,242.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,266,308.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 2,514,420.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 2,067,092.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,613,444.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын

төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 2,747,414.7 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 163,162.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 104,600.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	257,151.31	154,786.83	(102,364.48)
Арилжааны банк дахь харилцах	10,533.71	8,375.83	(2,157.88)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	78.11	-	(78.11)
Банкинд байгаа бэлэн мөнгөн дүн	267,763.13	163,162.66	(104,600.47)

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 154,786.8 мянган төгрөгийн 24,5 хувь буюу 39,976.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 12,1 хувь буюу 19,772.4 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн, 54,8 хувь буюу 89,396.1 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 3,5 хувь буюу 5,641,7 мянган төгрөгийг байгалийн нөхөн сэргээлт барьцаа сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл арилжааны банканд байршиж байна.

Аудитын илрүүлэлт

Шалгаагдагч байгууллагын харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим төлбөрийн баримттай тулгалт хийхэд ЗДТГ 38,735.2 мянган төгрөгийн худалдан авалтыг баталгаажуулаагүй байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 218,444.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 102,935.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	10,530.15	10,076.08	(454.07)
Байгууллагаас авах авлага	70,973.44	-	(70,973.44)
Хувь хүмүүсээс авах авлага	239,875.67	208,368.05	(31,507.62)
Банкинд байгаа бэлэн мөнгөн дүн	321,379.25	218,444.13	(102,935.12)

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэл 218,444.1 мянган төгрөгийн 4,6 хувь буюу 10,076.1 мянган төгрөгийг зээлийн хүүгийн авлага, 95,4 хувь буюу 208,368.1 мянган төгрөгийг хувь хүмүүсээс авах авлага дансны үлдэгдэл эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 100 хувь буюу 208,368.1 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн авлага байна.

Хувь хүмүүсээс авах авлагын 99,2 хувь буюу 206,639.9 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн авлага, 0,8 хувь буюу 1,728.1 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн авлага байна.

Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад хоршоо хөгжүүлэх сангийн авлагыг зээлийн авлага, хувь хүмүүсээс авах авлага гэж 2 өөр дансанд бүртгэсэн байна.

Эмийн эргэлтийн сангийн авлагын оны эхний 1,728.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байна.

3.4.3 Бараа материал

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 101,277.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 144,311.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	4,913.38	92.07	(4,821.31)
Эм боох материал	52,406.58	29,838.32	(22,568.26)
Бичиг хэргийн материал	4,106.41	2,341.16	(1,765.25)
Аж ахуйн материал	28,890.04	8,848.29	(20,041.75)
Сэлбэг хэрэгсэл	3,569.80	2,760.00	(809.80)
Түлш, шатах тослох материал	12,932.77	6,508.60	(6,424.17)
Барилгын засварын материал	1,140.00	-	(1,140.00)
Хүнсний материал	3,223.12	-	(3,223.12)
Бусад хангамжийн материал	126,607.78	43,089.52	(83,518.26)
Мал амьтад	7,800.00	7,800.00	-
БАРАА МАТЕРИАЛ	245,589.87	101,277.96	(144,311.91)

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 101,277.9 мянган төгрөгийн 67,6 хувийг ЗДТГ, 31,1 хувийг эмийн эргэлтийн сан, 1,4 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 101,277.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 144,311.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд харьяа байгууллагууддаа санхүүгийн тайлангаа нэгтгэдэг болсноор Эрүүл мэндийн төвийн 60,447.8 мянган төгрөг, ЕБС-ийн 44,251.3 мянган төгрөг, СӨБ-ийн 30,627.8 мянган төгрөг, Соёлын төвийн 34,513.6 мянган төгрөгийн, нийт 169,840.5 мянган төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд сургуулийн нүүрсний үлдэгдэл 2,769.2 мянган төгрөгийг нэгтгэж тайлагнасан алдааг залруулсан.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,588,242.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,266,308.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	3,287,124.02	959,380.77	(2,327,743.25)
Авто-тээврийн хэрэгсэл	43,443.17	102,934.03	59,490.86
Машин тоног төхөөрөмж(компьютер)	162,619.76	226,804.18	64,184.42
Тавилга, аж ахуйн эд хогшил	60,153.92	64,365.97	4,212.05
Ном	32,124.74	-	(32,124.74)
Програм хангамж	623.03	369.53	(253.50)
Бусад биет бус хөрөнгө	268,462.00	234,388.00	(34,074.00)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,854,550.64	1,588,242.48	(2,266,308.16)

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,588,242.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,266,308.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 2,514,420.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 153,251.5 мянган төгрөгийн өртгөтэй 1075 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчилд зөвлөмж өгсөн.

3.4.5 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 4,035.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,732.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	168.21	-	(168.21)
Байгууллагад төлөх өглөг	8,177.60	4,035.00	(4,142.60)
Хувь хүмүүст төлөх өглөг	422.00	-	(422.00)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,767.81	4,035.00	(4,732.81)

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 1,823.4 мянган төгрөгөөр буурсан нь ЭМТ, ЕБС, СӨБ, соёлын төв нь улсын төсөвт байгууллага болж орон нутгийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 4,035.0 мянган төгрөг нь байгалийн нөхөн сэргээх, барьцаа сангийн өглөг байна.

Аудитын илрүүлэлт:

Сургуулийн өглөгийн үлдэгдэл 2,769.2 мянган төгрөгийг нэгтгэж тайлагнасан алдааг аудитын явцад залруулсан.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,067,092.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,613,444.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	1,449,607.57	825,219.30	(624,388.27)
Хуримтлагдсан үр дүн	2,197,054.79	1,111,370.07	(1,085,684.72)
Өмнөх үеийн үр дүн	832,298.79	4,208,223.29	3,375,924.50
Тайлант үеийн үр дүн	1,364,756.00	(3,096,853.21)	(4,461,609.21)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,033,874.07	130,502.86	(903,371.21)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,680,536.43	2,067,092.23	(2,613,444.20)

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 2,613,444.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 624,388.3 мянган төгрөгөөр,

хөрөнгийн дахин үнэлгээ 903,371.2 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 3,375,924.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 4,461,609.2 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Архуст сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн “сумын 2022 оны төсөв батлах тухай” 01 дүгээр тогтоолоор 2022 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 260,427.6 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 962,284.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Архуст сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн “Сумын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 01 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого хэмжээ өөрчлөгдөөгүй, 2022 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 842,220.9 мянган төгрөгөөр, нийт 120,063.2 мянган төгрөгийг тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 260,427.6 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 287,285.5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 105,921.6 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 37,074.2 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 136,512.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 200,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 287,285.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 389,721.4 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 80,016.2 мянган төгрөг, эхний үлдэгдэл 51,530.3 мянган төгрөг, ОНХС 157,845.6 төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 18,433.9 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 823,977.6 мянган төгрөг буюу 79,1 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 32,889.1 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 2,141.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 10.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 38.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 7.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 4.6 мянган төгрөг, хөрөнгийн зардал 25,302.9 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээл 157,848.9 төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Цалин шимтгэлийн зардал орон тоо дутуу ажилласнаас, хөрөнгийн зардал тендер сонгон шалгаруулалттай холбоотойгоор хэмнэгдсэн байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- үндсэн үйл ажиллагааны зардал	48,234.2	48,231.2	2.9	99,9
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- үндсэн үйл ажиллагааны зардал	219,353.4	195,103.5	24,249.9	88,9
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	27,406.3	27,384.9	21.4	99,9
4	Соёлыг төв-тогтмол зардал	17,795.5	17,524.5	271.0	98,4
5	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	14,834.2	14,822.9	11.4	99,9
6	ЭМТөвийн-тогтмол зардал	20,458.9	20,458.9	0	100,0
7	Хоршоог хөгжүүлэх сан-үндсэн үйл ажиллагааны зардал	200,000.0	80,016.8	119,983.2	40,0
8	ОНХС-хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	181,995.8	157,845.6	24,150.2	86,7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 20,395.8 мянган төгрөг, ИТХ 300.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн эхний үлдэгдэл 78.1 мянган төгрөг нийт 20,773.9 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 8 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/ мянган төгрөгөөр/

	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
	70105-Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01-2022.12.31	Сумын ИТХТ. тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах. мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж. хуралдааныг зохион байгуулж. мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч. тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах. мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын. зөвлөл хуралдааныг зохион байгуулж жилд 8 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 90	48,234.2	48,231.2
	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Сумн засаг даргын мөрийн хөтөлбөр 8 зорилт 104 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 92.21	219,353.4	195,103.5
	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01-2022.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 7 зорилт 35 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 91.	27,406.3	27,384.9
	71702-Соёлыг төв	2022.01.01-2022.12.31	Соёлын төв нь 4 зорилт 32 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 92.6	17,795.5	17,524.5
	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01-2022.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 7 зорилт 37 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 90	14,834.2	14,822.9
	71602-ЭМТөв	2022.01.01-2022.12.31	Нийт 5 төрлийн үзлэгт 1709 иргэдийг хамруулна.	Урьдчилан сэргийлэх үзлэгт иргэн бүрийг хамруулахаар 1.Артерийн даралт ихсэх илрүүлэг үзлэг 18 дээш насны 861-694=80.6 2.Чихрийн шижин хэв шинж -2 илрүүлэх үзлэгт 35-дээш насны 538-388=72.1 4.Хөхний үзлэгт 20-60 насны 312-202 эмэгтэйчүүд хамрагдан 64.5-тай байна.	20,458.9	20,458.9

				5.Умайн хүзүүний хавдар илрүүлэх эсийн шинжилгээнд зорилтот 30-60 насны 74 хамрагдахаас 73 эмэгтэйчүүд хамрагдан 98.6-тай байна. Иргэн бүрийн эрт илрүүлэг үзлэгт насны ангилалаар 0-17 насны 479-352=73.4 байна. Эрүүл 64 хүүхдэд эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн. Лавлагаа шатлалын ЭМБ шилжүүлсэн давхардсан тоогоор 280 хүүхэд.анхан шатны ЭМБ хяналтанд авсан 107 хүүхдийг хяналтанд авсан. 18-30 насны 56 иргэн БНЭ тэй гэрээ хийж суманд ирж үзлэг хийгдсэн. УНТЭ-т ЭМТ-н 12 ажилтан хамрагдсан.		
	70106-Хоршоог хөгжүүлэх сан	2022.01.01-2022.12.31	2022 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх	2022 оны 01 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100	200,000.0	80,016.8
			ХХС-аас иргэн. хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлагдаж 1 ААНБ 40.0 сая төг зээл авсан байна.		
	70106-ОНХС	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 14 төслийг 181995.8 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 13. хийгдээгүй 1 ажил байна. Хэрэгжилт 92.8	181,995.8	157,845.6

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 05/16 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт зардал 3,979,072.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 59,686.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 47,748.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Архуст сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй байна. Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын 3 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй ба зээл олголттой холбоотой 61,685.9 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой 1 тушаал болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 181,995.8 мянган төгрөгийн 17 ажлыг гэрээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 05/152 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 9 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	3,577.2	3	3,577.2	100
Албан шаардлага	2	48,658.7	2	48,658.7	100
Зөвлөмж	4	47,682.8	4	47,682.8	100
Нийт дүн	9	99,918.7	9	99,918.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 2,767,586.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад залруулав.

1. Байгалийн нөхөн сэргээлт барьцаа санд байршуулсан хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгө 1,950.0 мянган төгрөгийг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Нэгтгэсэн үр дүнгийн тайлан, тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг 10,085.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийг 387,377.8 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

3. Нэгтгэсэн санхүүгийн тайланд 2,365,404.5 мянган төгрөгийн шилжүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгийг тодруулга тайланд бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан хөрөнгөөр бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

4. Нэгтгэсэн санхүү байдлын тайланд ЕБС-ийн 2,769.2 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэл болон өглөгийн үлдэгдлийг нэгтгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан

нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар. энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 34,759.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 32,440.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч, 2,319.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Төлбөрийн акт

Сумын Засаг даргын захирамжаар 5 иргэний тариалангийн зориулалттай 290 га газрын эзэмших эрхийг шилжүүлэхдээ 2,319.1 мянган төгрөгийн татвар суутгаж төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 “эрхийн шимтгэлийн орлогыг нийт дүнгээр”, 21 дүгээр зүйлийн 21.2.4 “энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 100,4 хувиар давж биелсэн боловч 4 нэр төрлийн орлого 12,1-81,5 хувиар буюу 16,322.4 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулгад 6 нэр төрлийн 16,118.2 мянган төгрөгийн татварын орлогыг татварын мэдээнээс зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар. энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон

хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	5	2,767,586.5			5	2,767,586.5	5	2,767,586.5		
ЗДТГ	1	11,606.0			1	11,606.0	1	11,606.0		
Дүн	5	2,779,192.5			6	2,779,192.5	6	2,779,192.5		

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Засаг дарга	3	34,759.7	1	2,319.7	2	32,440.6				
ЗДТГ	3	216,134.4			1	38,735.2	1	153,251.5	1	24,147.7
Дүн	6	250,894.1	1	2,319.7	3	71,175.8	1	153,251.5		

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ОНХС	1	181,995.8					1	181,995.8
ХХС	1	61,685.9					1	61,685.9
ЭЭС	1	25,576.0					1	25,576.0
Дүн	3	269,257.7					3	269,257.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	3	269,257.7					3	269,257.7